



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2021 оны А/283 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос улсад зохион байгуулагдах “Био бэлдмэлийн зохицуулалтыг сайжруулах” сэдэвт олон улсын хуралд оролцох бэлтгэл ажлыг хангах “Ажлын хэсэг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга	Т. Мөнхтуул	Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд	П.Цэцгээ	Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ч. Баяр	Эмийн бүртгэлийн зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Б.Тэмүүлэн	Гадаад хамтын ажиллагаа, гэрээний асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Уранбилэг	Вакцин, биобэлдмэлийн чанар аюулгүй байдал зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Гадаад томилолтын бэлтгэл ажлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдолд албан хаагчдыг ажлын бус цагаар ажиллуулах болохыг Ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (Н.Уянга)-д даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 01168